



**“БҮТЭЭЛЧ ҮЙЛС” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2015 оны 3 сарын 10 өдөр

Дугаар 3

Налайх дүүрэг

Г Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Г
хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76.1.8 зүйл заалт, “Бүтээлч Үйлс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бүтээлч Үйлс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 4 сарын 22-ны өдрийн 10 цагт компанийн өөрийн байранд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

2.1 Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн аудитын тайлан, дүгнэлтийг хэлэлцэж батлах

2.2 Компанийн 2015 оны бизнес үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах

2.3 Компанийн дотоод бүтэц, зохион байгуулалтыг хэлэлцэж батлах

2.4 Бусад асуудлууд

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан өдөр тутмын сонинд хурлын зар хүргүүлсүгэй.

4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 3 сарын 25-ны өдрөөр тогтоосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М.НЭРГҮЙ